



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 628

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 он, 2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 756.9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

2.1. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж, тендер шалгаруулалтын журмыг зөв хэрэглэж худалдан авах үйл ажиллагааг төлөвлөж ажиллах.

3. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгтөд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

3.4. Хэнтий салбарын цайны газрын түрээсийн төлбөрийн Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих 4,121.7 мянган төгрөгийг 2021 онд багтаан төвлөрүүлэх;

132007039

3.5.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууц, төв байрны дээвэр дээр байрлах “Мобиком корпораци” ХХК-ийн антен зэргийг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай түрээсийн гэрээ байгуулж ажиллах;

3.6.Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг сайжруулах зорилгоор компанийн хашаанд ил задгай хадгалж байгаа аваарын нөөц, зарим бараа материалыг хадгалах агуулахын байрны санхүүжилтийн эх үүсвэрийг 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэх арга хэмжээ авах;

3.7.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.8.Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д дахь заалтыг дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхгүй байх;

3.9.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 14 –ний өдрийн
688..... дугаар тогтоолын хавсралт

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат
компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Үргүй зардлыг санхүүжүүлсэн	28.2	Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”	Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, дэд захирлууд, Багануур салбарын захирлын Багануурт ажиллах хугацааны орон сууцны түрээсийн төлбөрийг санхүүжүүлэхгүй байх.
2	Салбарын дээд шатны байгууллагын гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн	7.6	Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоол	Цаашид байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй зардлыг санхүүжүүлэхгүй байх.
3	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслэхдээ эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулаагүй	12.5	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоол	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол болон холбогдон гарсан журмыг мөрдөх
4	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан	68.5	ТБОНӨТХ-ийн 11.8 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2019 оны 04, 237, 2020 оны 22, 242 дугаар тушаал, ТУЗ-ийн 2019, 2020 оны 01, 26 дугаар тогтоол	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө бэлтгэх
5	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	640.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дэх заалт	Тендер шалгаруулалтын /арга/ журмыг зөв сонгож худалдан авалтыг төлөвлөх
НИЙТ ДҮН:		756.9		